



**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохиролцогч Талууд" гэх/,

Хоёр улсын гадаад худалдааны харилцааг хөгжүүлэхэд найдвартай, үр ашигтай олон улсын автотээврийн үйлчилгээ үзүүлэх нь нэн чухал болохыг хүлээн зөвшөөрч,

Эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр олон улсын автотээврийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын автотээвэрлэлтийг хэнгөвчлөх зорилгоор

Дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

1 дүгээр зүйл.

Хамрах хүрээ

1. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээвэрлэгч тээврийн хэрэгслээр Хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд, эсхүл тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд болон Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс гуравдагч улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, буцах чиглэлийн олон улсын авто замаар гүйцэтгэх зорчигч ба ачаа тээвэрт хамаарна.

2. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талуудын олон улсын бусад гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг үл хөндөнө.

2 дугаар зүйл.

Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан нэр томьёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

- (1) "Тээвэрлэгч" гэж Хэлэлцэн тохиролцогч Талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, тухайн Хэлэлцэн тохиролцогч талын дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх эрхтэй хувь хүн, эсхүл хуулийн этгээдийг;
- (2) "Тээврийн хэрэгсэл" гэж тээвэрлэгчийн эзэмшиж байгаа эсхүл хууль ёсоор ашиглаж буй дараах тээврийн хэрэгслийг:
"зорчигч тээврийн хэрэгсэл" гэж зорчигч тээвэрлэх зориулалтын 8-аас дээш суудалтай (жолоочийн суудлаас гадна) тээврийн хэрэгслийг;
"ачааны тээврийн хэрэгсэл" гэж ачаа тээвэрлэх зориулалтын ачааны автомашин, авто угсраа болон угсраа тээврийн хэрэгслийг ойлгоно.
- (3) "Зорчигчийн тогтмол тээвэрлэлт" гэж Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллагуудын урьдчилан тохиролцсон тээврийн маршрут, зорчигчдыг буулгах, суулгах зогсоол, хөдөлгөөний цагийн хуваарь, тээврийн тарифын дагуу хийгдэх зорчигч тээвэрлэлтийг;
- (4) "Зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт" гэж зорчигчийн тогтмол тээвэрлэлтээс бусад зорчигч тээвэрлэлтийг;
- (5) "Тээврийн хэрэгслийн зөвшөөрөл" гэж Хэлэлцэн тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллагаас Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгслээр өөрийн улсын нутаг дэвсгэрт олон улсын автотээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн баримт бичгийг;
- (6) "Аюултай ачаа" гэж Хэлэлцэн тохиролцогч Талуудын байгуулсан, эсхүл нэгдэн орсон олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээр болон тээвэрлэлт явагдаж буй улсын дотоодын хууль тогтоомж, стандартаар аюултайд

тооцсон ачаа, үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй бодис, эд зүйлсийг;

- (7) "Онцгой зөвшөөрөл" гэж Хэлэлцэн тохиролцогч нэг Талын холбогдох байгууллагаас өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу даац хэтэрсэн, овор ихтэй, задрах боломжгүй, аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг өөрийн улсын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын тээвэрлэгчид олгох нэг удаагийн зөвшөөрлийг;
- (8) "Гуравдагч улсаас/руу зорчих зөвшөөрөл" гэж Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрээс гуравдагч улс руу, эсхүл гуравдагч улсын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэг удаагийн тээвэрлэлт хийхийг зөвшөөрсөн баримт бичгийг;
- (9) "Хоёр талын тээвэрлэлт" гэж Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрээс эхэлж, Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт дуусах тээвэрлэлтийг;
- (10) "Дамжин өнгөрөх тээвэрлэлт" гэж тээвэрлэлтийн эхлэх, төгсөх цэг нь дамжин өнгөрүүлж буй нэг Талын нутаг дэвсгэрийн гадна орших цэгийн хооронд хийх тээвэрлэлтийг;
- (11) "Гуравдагч улсын тээвэрлэлт" гэж Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл нь тээвэрлэлтээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт эхэлж гуравдагч улсын нутаг дэвсгэрт дуусах, эсхүл гуравдагч улсын нутаг дэвсгэрт эхэлж, Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт дуусах тээвэрлэлтийг;
- (12) "Эрх бүхий байгууллага" гэж энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэгч Эрх бүхий байгууллага болон түүнээс эрх олгосон байгууллагыг тус тус хэлнэ.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ.
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ЗӨВШӨӨРЛИЙН СИСТЕМ**

**3 дугаар зүйл.
Ерөнхий заалт**

1. Энэхүү хэлэлцээрийн 8 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл нь хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас олгох тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, эсхүл онцгой зөвшөөрөл авна.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага жил бүр зорчигч, ачаа тээвэрлэх зөвшөөрлийн тоог тохиролцож, харилцан солилцоно. Зөвшөөрлийг Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллага, эсхүл түүнээс эрх олгосон, тухайн улсад бүртгэлтэй байгууллагаас тээвэрлэгчид олгоно.

3. Зөвшөөрөл нь зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг, хариуцсан албан тушаалтны гарын үсэгтэй байна.

4. Тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг бусад тээвэрлэгч, болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

5. Тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг нэг удаад зөвхөн нэг тээврийн хэрэгсэлд ашиглана. Тээврийн хэрэгслийн зөвшөөрөл нь дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна. Чиргүүл болон хагас чиргүүлтэй ачааны автомашины хувьд тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг зөвхөн чирэгчид олгоно.

6. Энэхүү хэлэлцээрийн 18 дугаар зүйлд заасан Хамтарсан хороо нь зөвшөөрлийн төрөл, загвар, тоо хэмжээ, солилцох журам болон зөвшөөрлийн ашиглалтын бусад нөхцөлийг тогтооно.

7. Тээвэрлэгч нь олгогдсон зөвшөөрлийг тээвэрлэлтийн явцад тээврийн хэрэгсэлдээ байнга авч явах ба хяналт, шалгалтын байгууллагын шаардлагаар шалгуулна.

4 дүгээр зүйл.

Зорчигчийн тогтмол тээвэрлэлт

1. Зорчигчийн тогтмол тээвэрлэлтийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага харилцан тохиролцож, зохион байгуулна.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь тээвэрлэгч, тээврийн хэрэгсэл, жолооч ба багийн гишүүд, зорчигчийг буулгах, суулгах буудал,

боомтууд, давтамж, тээврийн маршрут ба тээврийн тариф зэрэг зорчигчийн тогтмол тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаар мэдээллийг урьдчилан солилцоно.

3. Зорчигчийн тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн хамтаар зорчигчдын шалгуулсан ачааг хилийн боомтын бодит нөхцөлийн хүрээнд бүхээгтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэж болох бөгөөд тухайн бүхээгтэй тээврийн хэрэгсэл нь зорчигчийн тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн хамт хилээр нэвтэрнэ.

4. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллага тухайн улсын тээвэрлэгчид зорчигчийн тогтмол тээвэрлэлт гүйцэтгэхийг зөвшөөрч, зөвшөөрлийг олгосон талаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

5. Зорчигчийн тогтмол тээвэрлэлтэд тасалбарын тогтолцоог хэрэгжүүлнэ. Зорчигчийн тогтмол тээвэрлэлт нь цахимаар тасалбар худалдахыг дэмжинэ.

5 дугаар зүйл.

Зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтийн зөвшөөрлийг тухай бүр олгоно. Зөвшөөрөл нь ирэх, буцах нэг удаагийн тээвэрлэлтэд хүчинтэй байна.

2. Зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт гүйцэтгэхдээ жолооч нь зорчигчдын нэрсийн жагсаалтыг тээврийн хэрэгсэлдээ авч явах бөгөөд уг жагсаалт нь эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон загварт нийцсэн байна.

6 дугаар зүйл.

Ачаа тээвэрлэлт

1. Энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, хоёр талын тээвэрлэлт, дамжин өнгөрөх тээвэрлэлт болон гуравдагч улсын тээвэрлэлт зэрэг ачаа тээвэрлэлтийг зөвхөн Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын эрх бүхий байгууллагаас олгосон зохих зөвшөөрөлтэй тээвэрлэгч гүйцэтгэнэ.

2. Хоёр улсын хооронд хийгдэх ачаа тээвэрлэлтийг байнгын болон түр хугацааны ачаа тээвэрлэлт гэж ангилна. "Байнгын ачаа тээвэрлэлт"-д уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүн болон Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий

байгууллагын харилцан тохиролцсон бусад ачаа тээвэрлэлт хамаарна. Байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгох ажлыг хялбаршуулах болон бусад нөхцөлийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд байгуулах протоколын холбогдох нөхцөлийн дагуу зохицуулна.

7 дугаар зүйл.

Онцгой зөвшөөрөл

1. Онцгой зөвшөөрөл нь тээврийн хэрэгслийн оврын хэмжээ, ачааны зөвшөөрөгдөх хамгийн их хэмжээ, тэнхлэгийн ачаалал нь тээвэрлэлт хийгдэх Хэлэлцэн тохиролцогч Талын хууль тогтоомж, техникийн стандартаас хэтэрсэн тохиолдолд шаардагдах бөгөөд тээвэрлэлт гүйцэтгэхээс өмнө Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад онцгой зөвшөөрөл авах хүсэлт гаргана.

2. Аюултай ачааны тээвэрлэлтийн хувьд, тээвэрлэгч нь тээвэрлэлтийг эхлүүлэхээс өмнө Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас олгох онцгой зөвшөөрлийг авна.

3. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага нь дотоодын хууль тогтоомжийн дагуу аюултай ачааны жагсаалт, тээвэрлэх нөхцөлийн талаарх мэдээллийг харилцан солилцоно.

4. Аюултай ачаа тээвэрлэлтийг Хэлэлцэн тохиролцогч Талуудын нэгдэн орсон олон улсын гэрээ болон тээвэрлэлт явагдаж буй улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл.

Зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх

1. Зөвшөөрлийг дараах тээвэрлэлтэд шаардахгүй. Үүнд:

- (1) үзэсгэлэн худалдаа, яармагийн зориулалттай үзмэр, тоног төхөөрөмжийн материал;
- (2) спортын үйл ажиллагаа, циркийн тоглолтын амьтад, түүнчлэн төрөл бүрийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд зүйлийг тээвэрлэх;

- (3) Тайзны чимэглэл, зураг авалтын зам, хөгжмийн зэмсэг болон кино зураг авах, радио, телевизийн нэвтрүүлэг хийх зориулалтын тоног төхөөрөмж, эд юмс;
- (4) нас барагчийн шарил, чандар;
- (5) шуудан;
- (6) байгалийн гамшиг тохиолдсон үед хүмүүнлэгийн болон эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардлагатай эд зүйлс;
- (7) нүүлгэн шилжүүлэх үеийн хөдлөх хөрөнгө;
- (8) улсын бүртгэлийн түр дугаартай шинээр худалдаж авсан ачаагүй тээврийн хэрэгсэл;
- (9) эвдрэл гэмтэлтэй тээврийн хэрэгсэлд техникийн тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэхэд ашиглах тээврийн хэрэгсэл;
- (10) эвдэрсэн эсхүл гэмтсэн зорчигч тээврийн хэрэгслийг солиход шаардлагатай зорчигчийн тээврийн хэрэгсэл.

2. Энэхүү хэлэлцээрийн 18 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан Хамтарсан хороо нь энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зөвшөөрлийн шаардлагаас чөлөөлөх тээвэрлэлтэд шаардлагатай бичиг баримтын талаар судалж, тодорхойлно. Энэхүү бичиг баримт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тээвэрлэлтийг гүйцэтгэх шаардлагыг хангасан байна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ.

ЖОЛООЧ БА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

9 дүгээр зүйл.

Жолоодох эрхийн үнэмлэх

1. Энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу олон улсын авто замаар зорчигч, ачаа тээвэрлэлт гүйцэтгэх жолооч нь тээврийн хэрэгслийн ангилалд тохирсон хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхтэй байна. Тус баримт бичиг нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын албан ёсны хэл рүү орчуулсан байна.

2.Энэхүү хэлэлцээрт дурдсан бүх бичиг баримтыг тээврийн хэрэгсэлд авч явах бөгөөд хяналт, шалгалтын байгууллагын шаардлагаар шалгуулна.

10 дугаар зүйл.

Тээврийн хэрэгсэл

1. Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл нь тухайн улсад бүртгэгдсэн улсын бүртгэлийн дугаартай, бүртгэлийн бичиг баримт, улсын код, техникийн хяналтын гэрчилгээтэй байна.

Монгол Улсын код: MGL.

Хятад Улсын код: CHN.

Хэлэлцэн тохиролцогч нэг талд бүртгэлтэй ачааны автомашин, чирэгч нь ачааг тээвэрлэхдээ Хэлэлцэн тохиролцогч нөгөө тал болон гуравдагч талд бүртгэлтэй чиргүүл, хагас чиргүүлийг чирж болно.

2. Тээврийн хэрэгслийн гаднах оврын хэмжээ, ачааны зөвшөөрөгдөх хамгийн их хэмжээ, тэнхлэгийн ачаалал болон бусад техникийн үзүүлэлтүүд нь тээвэрлэлт хийгдэж буй улсын дотоодын хууль тогтоомж, дүрэм журам, техникийн стандартад нийцсэн байна.

11 дүгээр зүйл.

Тээвэрлэлтийн шаардлага

1. Хэлэлцэн тохиролцогч Талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орших хоёр цэгийн хооронд зорчигч, ачаа тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

2. Онцгой зөвшөөрлийн дагуу маршрутыг тогтоосон бол энэ чиглэлийн дагуу тээвэрлэлт гүйцэтгэнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч Талуудын тээвэрлэгчдийг тээврийн үйл ажиллагаанд оролцох эрх тэгш нөхцөл бүрдүүлж, тэдний хууль ёсны эрх ашгийг ханган ажиллана.

4. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллага өөрийн нутаг дэвсгэрт байгаа тээврийн хэрэгслийн ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай үед яаралтай тусламж үзүүлнэ. Хэрэв боломжтой бол Хэлэлцэн тохирогч талууд

тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг мэдээллийн системээр дамжуулан солилцож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ.

БУСАД ЗААЛТ

12 дугаар зүйл.

Татвар, хураамж, төлбөрүүд

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээвэрлэгч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын автозамаар зорчигч, ачаа тээвэрлэлт гүйцэтгэхэд тээврийн хэрэгсэл өмчлөх, ашиглахтай холбоотой тээврийн орлогын татвар, хураамж болон бусад төлбөрөөс чөлөөлөгдөнө.

Дээрх заалтад ялгаварлан гадуурхахгүй байх зарчим дагуу төлбөртэй зам, гүүр, нүхэн гарцаар нэвтрэх төлбөр, хураамж тусгагдаагүй болно.

2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч Талууд ачаа тээвэрлэх явцад Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын тээвэрлэгчийн өөрийн нутаг дэвсгэрт оруулж ирсэн дараах ачаанаас гаалийн татвар, хураамж авахгүй:

(1) тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй технологийн болон хийцийн хувьд холбоотой, үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн түлшний саванд байгаа шатахуун, тээврийн хэрэгслийн халаах, хөргөх, төхөөрөмжийн нэг хэсэг болгон үйлдвэрлэгчээс үйлдвэрлэсэн чиргүүл, хагас чиргүүлүүдийн түлшний саванд агуулагдах шатахуун;

(2) тээврийн хэрэгсэлд зайлшгүй хэрэглэхэд тохирох хэмжээний тосолгооны материал;

(3) тээвэрлэлтийн явцад тээврийн хэрэгсэлд эвдрэл, гэмтэл гарсан үед засвар үйлчилгээнд шаардагдах сэлбэг, багаж хэрэгсэл.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ашиглагдаагүй сэлбэг, багаж хэрэгслийг өргүүлэн тээвэрлэнэ. Сольсон хуучин сэлбэгийг тухайн улсаас авч буцах, эсхүл тухайн Хэлэлцэн тохиролцогч талын гаалийн хууль тогтоомжийн дагуу устгалд оруулна.

13 дугаар зүйл.

Хилийн хяналт шалгалт

1. Хил, гааль (хорио, цээрийн хяналт шалгалт) болон хилийн бусад хяналт шалгалтыг Хэлэлцэн тохиролцогч Талуудын нэгдэн орсон олон улсын хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ. Дээр дурдсан дүрэм журам болон нөхцөлийн дагуу шийдвэрлэх боломжгүй асуудлыг Хэлэлцэн тохиролцогч Тал бүрийн дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

2. Хил, гааль (хорио цээрийн дэглэм, хяналт шалгалт) болон хилийн бусад хяналт нь зорчигчийн тогтмол тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл, хүнд өвчтөн, амьтан, түргэн гэмтэх, муудах, аюултай болон хүмүүнлэгийн ачааг шалгахад давуу эрх олгоно.

14 дүгээр зүйл.

Тээврийн хяналт шалгалт

1. Тээврийн хяналт шалгалтыг Хэлэлцэн тохиролцогч Талуудын байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ. Дээр дурдсан гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэх боломжгүй асуудлыг талууд өөр өөрийн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2. Зорчигчийн тогтмол тээвэрлэлтийг гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл, хүнд өвчтөн, мал амьтан, түргэн муудах бүтээгдэхүүн, аюултай ачаа, хүмүүнлэгийн тусламжид ашиглах барааны тээвэрлэлт гүйцэтгэхэд тээврийн хяналтын байгууллагаас хяналт шалгалтыг нэн тэргүүнд гүйцэтгэнэ.

15 дугаар зүйл.

Дотоодын хууль тогтоомжид нийцсэн байдал

1. Энэхүү Хэлэлцээр болон Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэгдэн орсон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрт тусгаагүй асуудлыг Хэлэлцэн тохиролцогч Талуудын дотоодын хууль тогтоомжоор зохицуулна.

2. Олон улсын автотээврийн үйл ажиллагаа эрхэлж буй Хэлэлцэн тохирогч талуудын тээвэрлэгчид энэхүү Хэлэлцээрт заагдсан зүйлүүд болон тээвэрлэлт хийж буй Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомж, дүрэм журам, түүний дотор замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөх ёстой. Зөрчил гаргасан тохиолдолд тухайн

Үйлдэл гарсан нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч талын улсын хууль тогтоомж, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

3. Тээвэрлэлтийн явцад Хэлэлцэн тохиролцогч нэг Талын тээврийн хэрэгсэл нь нөгөө Талын нутаг дэвсгэрт зам тээврийн осол гаргасан тохиолдолд тухайн осол гарсан улсын хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, нөгөө талд мэдэгдэх ба ослыг мөрдөн шалгах үйл ажиллагааг шаардлагатай мэдээллээр хангана.

16 дугаар зүйл.

Даатгал

Энэхүү Хэлэлцээрийн дагуу олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэхдээ тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч нь тээвэрлэлт явагдаж буй улсын нутаг дэвсгэрт гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг барагдуулах хүчин төгөлдөр хариуцлагын даатгалтай байна.

ТАВДУГААР ХЭСЭГ.

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

17 дугаар зүйл.

Эрх бүхий байгууллага

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэгжүүлэхээс үүдэн гарах аливаа маргааныг эрх бүхий байгууллагууд хэлэлцэх, зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага нь:

Монгол Улсын хувьд: Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам, түүнээс эрх олгосон байгууллагууд;

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хувьд: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тээврийн яам, түүнээс эрх олгосон мужийн түвшний зам тээврийн эрх бүхий байгууллагууд.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага нь энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх протоколыг хэлэлцэн тохиролцоно.

18 дугаар зүйл.

Хамтарсан хороо

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага нь энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олон улсын автотээвэрлэлтийн асуудлыг зохицуулах, шийдвэрлэх үүрэг бүхий Хамтарсан хороо байгуулна.

2. Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага Хамтарсан хорооны хурлыг жил бүр, эсхүл шаардлагатай үед зохион байгуулж, дараах асуудлыг зөвшилцөнө:

- a) энэхүү Хэлэлцээр болон Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага хооронд байгуулсан бусад баримт бичгийн хэрэгжилт;
- b) олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл солилцох асуудал;
- c) энэхүү Хэлэлцээрийн хүрээнд тээврийн маршрутыг тодорхойлох;
- d) Хэлэлцэн тохиролцогч Талууд нь олон улсын автотээвэрлэлтийн тоо хэмжээг харилцан мэдээлэх;
- e) энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудал.

3. Шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч Талууд холбогдох байгууллагын төлөөлөгчдийг Олон улсын автотээврийн тухай Хамтарсан хорооны хуралд урьж оролцуулж болно.

19 дугаар зүйл.

Маргаан шийдвэрлэх

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэх явцад маргаан гарвал Хэлэлцэн тохиролцогч Талуудын хооронд хэлэлцэх, зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

20 дугаар зүйл.

Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах

Энэхүү Хэлэлцээрт харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно. Протокол нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

21 дүгээр зүйл.
Хүчин төгөлдөр болох ба цуцлах


1. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийг хангасан тухайгаа ноот бичиг солилцох замаар харилцан мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан талаар дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрийг хугацаагүй байгуулав. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээр нь мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 6 сарын дараа хүчингүй болно.

3. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр" нь хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг Бөжин хотноо 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр монгол, хятад болон англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

